

ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ БҮТЭЦ, ЗОХИЦУУЛАХ ХАРИЛЦАА, ХАМРАХ ХҮРЭЭ

Ойн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл 5 зүйлтэй байхаар боловсруулж байна.

Хуулийн төсөлд оруулсан өөрчлөлтийг тоймловол:

2.1. Ойн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4 дэх хэсгийн “бэлтгэгдсэн” гэж өнгөрсөн цагаар бичигдсэн байх учир иргэд хууль бусаар мод бэлтгэсний дараа бэлтгэгдсэн модондоо эрхийн бичиг, гарал үүслийн гэрчилгээг авахаар заасан, хууль зүйн хийдлийг бий болгох тохиолдолд гардаг. Иймд Ойн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4 дэх хэсгийн “бэлтгэсэн” гэснийг “бэлтгэх” гэж өөрчлөх зохицуулалтыг тусгана.

2. Ойн тухай хуулийн 32.5 дахь хэсгийг Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.5.3.4 дэх дэд заалттай нийцүүлэх зохицуулалтыг хийнэ.

3. Хууль бус зөвшөөрөл олголтыг зогсоох зорилгоор Ойн тухай хуулийн 32.3 дахь заалтанд мод бэлтгэх, төрөл тоо хэмжээг тогтоохдоо” үйлдвэрлэлийн ашиглалт явуулах эрх бүхий аж ахуйн нэгжид үйлдвэрлэлийн огтлолтоор, ойд арчилгаа цэвэрлэгээ явуулах эрх бүхий аж ахуйн нэгжид арчилгаа, цэвэрлэгээний огтлолтоор олгож байхаар ойн мэргэжлийн байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг үндэслэж байх тодотголыг оруулах зохицуулалтыг хийнэ.

4. Ойн тухай хуульд мод, модон материалын захын үйл ажиллагаанд “ зөвшөөрөлгүй мод модон материал борлуулахгүй байх”, “мод тээвэрлэсэн машиныг өглөөний 8 цагаас оройн 20 цагийн хооронд оруулж байх” зэрэг хяналт тавих боломжийг олгох, энэ дэглэмийг зөрчсөн захын үйл ажиллагаа эрхлэх үйл ажиллагааг зогсоох арга хэмжээг авах үүднээс өөрчлөлт оруулахаар байна.

5. Ойгоос мод бэлтгэх эрхийн бичиг, гарал үүслийн гэрчилгээ олгох журмыг зөрчсөн албан тушаалтныг ажлаас халах заалт шинээр хууль тогтоомжид нийцүүлэх байдлаар хариуцлагын тогтолцоог нэмэгдүүлнэ.

6. Ойгоос мод бэлтгэх ажлыг төлөвлөх, зохион байгуулах, мод бэлтгэх болон хяналт тавих үйл ажиллагааг зохицуулах шаардлагын үүднээс Ойгоос мод бэлтгэхтэй холбогдсон харилцааг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батласан журмаар зохицуулана.

7. Мөн зөвшөөрлийн дагуу бэлтгэсэн модыг зөвшөөрөлгүй тээвэрлэсэн бол торгуулийн шийтгэл ногдуулах шинэ эрх зүйн орчин бүрдүүлэх зэрэг болно.

ГУРАВ. ХУУЛЬ БАТЛАГДСАНААР БИЙ БОЛОХ НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГ, ХУУЛЬ ЗҮЙН ҮР ДАГАВАР, ТҮҮНИЙ АЧ ХОЛБОГДОЛ

Хууль батлагдсанаар экологийн тогтвортой байдлыг хадгалах байгаль орчныг хамгаалах, нийгэм, эдийн засаг, хууль зүйн дараах үр дүнд хүрэх нөхцөл бүрдэх болно:

Ойн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналт үлэмж сайжирч, хууль бус мод бэлтгэлийг бууруулахад иргэдийн оролцох оролцоо нэмэгдэнэ.

Ингэснээр олон нийтийн идэвхтэй оролцоонд тулгуурласан хяналтын тогтолцоог бий болгох, урамшуулах, урамшуулал олгох санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхой болгох замаар хууль бус мод бэлтгэлтэй тэмцэх эрх зүйн орчинг сайжирна.

Ойн тухай хууль тогтоомж болон Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилт, хууль хоорондын уялдаа сайжран, давхардал хийдэл арилна.

Төр, иргэн, хувийн хэвшлийн байгууллага хоорондын хариуцлага дээшилж, хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагын хэмжээ өссөнөөр тоо, чанарын мэдэгдэхүйц ахиц гарна гэж тооцож байна.

“Ойн судалгаа хөгжлийн төв” УТҮГ–ийн судалгааны ажлын тайлан-аас үзэхэд сүүлийн 5 жилийн дундажаар Ойн тухай хууль зөрчиж, Цагдаагийн байгууллагад Эрүүгийн хэрэг үүсэн шалгагдсан гэмт хэргийн тоо -230, Мэргэжлийн хяналтын байгууллагад бүртгэгдсэн зөрчлийн тоо – 2040 байна. Эрүүгийн хэрэг зөрчлийн тоон үзүүлэлтийн 50 орчим хувийг иргэдээс ирүүлсэн мэдээлэл бүрдүүлсэн гэж үзвэл БХСанд төсөвлөх урамшууллын мөнгөн хөрөнгийн доод хэмжээг 60,0 сая байна гэж тооцоолж байна.

Байгаль хамгаалах сангийн орлого бүрдүүлэх эх үүсвэрт хохирлын нөхөн төлбөрийн орлого төвлөрч, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд зарцуулагдах болно.

Мөн байгаль хамгаалах санд төвлөрч байгаа экологи эдийн засгийн үнэлгээгээр тооцогдсон хохирлын нөхөн төлбөрийн хэмжээ нэмэгдэж, эргээд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах мөнгөн хөрөнгийн дүн шууд хамаарлаар нэмэгдэх болно.